



Quota for foreign employees for 2021

The Government of Mongolia (the “Cabinet”) updates the foreign worker quota for entities operating in Mongolia annually. For 2021, the Cabinet updated the quota by issuing the Resolution #123 dated 30 September 2020 (the “Resolution #123”).

Contacts :

Michael Ahern

Partner, Tax and Legal Services
Leader
michael.ahern@pwc.com

Tsendmaa Choijamts

Director, Tax and Legal Services
tsendmaa.choijamts@pwc.com

Maryna Tarnavska

Senior Manager
tarnavska.maryna@pwc.com

Munkhjargal Ragchaakhuu

Senior Legal Consultant
munkhjargal.ragchaakhuu@pwc.com

PwC Tax TMZ LLC

Central Tower 6th floor
Suite 603, Ulaanbaatar
14200, Mongolia
Tel : + 976 70009089
Fax : +976 11 322068
www.pwc.com/mn

In connection with the COVID-19 pandemic, the work permit for foreign employees shall be issued on a basis of the National Emergency Commission’s decision for 2021.

As it is specified in the Resolution #123, in the heightened emergency situation, the first priority for work permits will be given to the management person body, engineer and technical staff and the second one to the staff who undertakes execution and support roles when it is absolutely necessary to allow foreign employees to work in Mongolia.

For 2021, the quota ranges from 10% to 70% depending on the industry sector and the number of Mongolian employees. For those sectors which are not directly mentioned in the Resolution #123, the total number of foreign employees should not exceed 5 % of the total headcount of the Mongolian staff if its total headcount is more than 20 as same as previous years.

Same as before, foreign invested companies can bring three foreign management staff and one investor/shareholder, who are not subject to the said quota.

If entities need to bring more expats to Mongolia for nationwide or large scale projects, they may be exempted from this ratio and a monthly workforce fee subject to approval of the Cabinet based on a general application procedure.

Under the Resolution #123, the quota for most of the sectors remains the same. However, some industries have been removed from the list as follows:

- Mining construction installation (the quota was 10 – 35%);
- Catering services (the quota was 10%);
- Professional and skill training activities (the quota was 20%).

However, pre-school education activities have been added to the list with the quota of 50 percent, while the quota for educational institutions offering international programs with intergovernmental agreements and foreign investment has increased by 5 percent from the previous year.

Please refer to the link below for more details

<https://www.legalinfo.mn/law/details/15668>

Should you have more questions with this regard, please do not hesitate to contact us.



pwc

This Alert is produced by PwC Tax TMZ LLC. The material contained in this alert is provided for general information purposes only and does not contain a comprehensive analysis of each item described. Before taking (or not taking) any action, readers should seek professional advice specific to their situation. No liability is accepted for acts or omissions taken in reliance upon the contents of this alert.

© 2020 PricewaterhouseCoopers Tax TMZ LLC.

All rights reserved. In this document, “PwC” refers to PricewaterhouseCoopers Tax TMZ LLC, which is a member firm of PricewaterhouseCoopers International Limited, each member firm of which is a separate legal entity.



2021 онд гадаадаас ажиллах хүч авах хувь хэмжээ

Монгол Улсын Засгийн газар (“Засгийн газар” гэх) Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын гадаадаас авах ажилтны хувь хэмжээг жил бүр шинэчлэн тогтоодог билээ. 2021 онд авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 123 тоот тогтоолоор (“Засгийн газрын 123-р тогтоол” гэх) Засгийн Газар нь шинэчлэн тогтоолоо.

Холбогдох хаяг:

Майкл Ахэрн

Партнер, Татвар, Хуулийн зөвлөх
үйлчилгээ
michael.ahern@pwc.com

Чойжамцын Цэндмаа

Гүйцэтгэх захирал, Татвар,
Хуулийн зөвлөх үйлчилгээ
tsendmaa.choijamts@pwc.com

Марина Тарнавская

Ахлах Менежер
tarnavska.maryna@pwc.com

Рагчаахүүгийн Мөнхжаргал

Хуулийн Ахлах Зөвлөх
munkhjargal.ragchaakhuu@pwc.com

ПрайсвотэрхаусКүүперс Такс ТМЗ ХХК

Сентрал Тауэр, 6 давхар
603 тоот, Улаанбаатар
14200, Монгол улс
Утас : + 976 70009089
Факс : +976 11 322068

www.pwc.com/mn

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан 2021 онд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг Улсын онцгой комиссын шийдвэрт үндэслэн олгохоор болсон байна.

Засгийн газрын 123-р тогтоолд дурдсанаар, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт байх хугацаанд эхний ээлжинд Монгол Улсад ажиллуулах зайлшгүй шаардлагатай удирдах болон инженер, техникийн ажилтанд, дараагийн ээлжинд гүйцэтгэх, туслах ажилтанд зохих журмын дагуу олгохоор тусгасан байна.

2021 онд гадаад ажилтны эзлэх хувь хэмжээ нь эдийн засгийн үйл ажиллагааны салбар чиглэл болон Монгол ажилтны тооноос шалтгаалан 10%-70% байхаар тогтоосон. Засгийн газрын 123-р тогтоолд урьдын адил тусгайлан заагаагүй салбарын хувьд 20-оос дээш монгол ажилтантай компаниудын гадаадын нийт ажилтны тоо нь Монгол ажилтны тооны 5%-иас хэтрэхгүй байна.

Мөн урьдын адил гадаадын хөрөнгө оруулалттай компанийн хувьд удирдах бүрэлдэхүүний 3 төлөөлөгч, хөрөнгө оруулагч/хувьцаа эзэмшигч 1 хүн энд заасан хувь хэмжээнд хамааралгүй юм.

Улсын хэмжээний эсхүл томоохон төсөлд олон тооны ажилтан гадаадаас ажиллуулах шаардлагатай этгээдийн хувьд Засгийн газраас шийдвэр гаргасан тохиолдолд дээрх хувь хэмжээ хамаарахгүй, мөн ажлын байрны сар бүрийн төлбөрөөс чөлөөлөгдөх боломжтой.

Засгийн газрын 123-р тогтоолоор ихэнх эдийн засгийн салбаруудын гадаад ажилтны эзлэх хувь хэмжээ нь өмнөх онд тогтоосон хувь хэмжээнээс өөрчлөгдөөгүй. Харин зарим эдийн засгийн салбар уг жагсаалтаас хасагдсан байна. Үүнд:

- Уул уурхайн барилга угсралт (хувь хэмжээ 10 – 35% байсан);
- Нийтийн хоолны үйлчилгээ (хувь хэмжээ 10% байсан);
- Мэргэжлийн болон ур чадвар олгох сургалтын үйл ажиллагаа (хувь хэмжээ 20% байсан).

Харин сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа 50 хувь байхаар жагсаалтад нэмэгдэж орсон бол Засгийн газар хоорондын гэрээтэй болон гадаадын хөрөнгө оруулалттай олон улсын хөтөлбөрөөр сургалт явуулдаг боловсролын байгууллагын хувьд тогтоосон хувь хэмжээ нь өмнөх оныхоос 5 хувиар нэмэгдэж 70 хувь болсон байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг доорх линкээс авна уу
<https://www.legalinfo.mn/law/details/15668>

Энэхүү мэдээлэлтэй холбоотой нэмж тодруулах зүйл байвал бидэнтэй холбогдоно уу.



Энэхүү мэдээллийг PwC Такс ТМЗ ХХК-аас бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, алдаа хийдлээс гарах аливаа хариуцлагыг бид хариуцахгүй болно.

© 2020 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурьдагдсан “PwC” нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох ПрайсвотэрхаусКүүперс Такс ТМЗ ХХК-г илэрхийлнэ.